

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

20__ оны __ сарын __ өдөр Дугаар _____ хот/аймаг

Энэхүү гэрээг /цаашид “гэрээ” гэх/ нэг талаас ХасБанк /цаашид “банк” гэх/, нөгөө талаас _____ иргэний үнэмлэх, _____ регистрийн дугаартай _____ овогтой _____ /цаашид “харилцагч”, хамтад нь “талууд” гэх/ нар дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр банкнаас харилцагчид цахим үйлчилгээг /цаашид “цахим үйлчилгээ” гэх/ үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2. Гэрээнд хэрэглэгдсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.2.1. “Цахим үйлчилгээ” гэж харилцагчийн мобайл, интернэт сувгаар дамжуулан авч буй энэхүү гэрээний 1.2.2, 1.2.3, 1.2.4-т заасан үйлчилгээг;
 - 1.2.2. “Мобайл банкны AMAR үйлчилгээ” /цаашид “мобайл суваг” гэх/ гэж харилцагч гар утсаа ашиглан авч буй энэхүү гэрээний 2.2.1-т заасан үйлчилгээг;
 - 1.2.3. “Интернэт банкны үйлчилгээ” /цаашид “интернэт суваг” гэх/ гэж харилцагч интернэтэд холбогдсон дурын компьютер буюу төхөөрөмжөөс <https://www.e-xacbank.com> цахим хуудсанд нэвтрэн орж авч буй энэхүү гэрээний 2.2.2-т заасан үйлчилгээг;
 - 1.2.4. “Хас-Info үйлчилгээ” гэж харилцагчийн ХасБанкинд байрших тус үйлчилгээнд бүртгүүлсэн дансанд хийгдсэн гүйлгээний мэдээллийг гүйлгээ хийгдсэн тухай бүрд харилцагчийн гар утас болон цахим шуудангийн хаягт хүргэх энэхүү гэрээний 2.2.3-т заасан үйлчилгээг;
 - 1.2.5. “Цахим үйлчилгээний данс” гэж харилцагчийн мобайл сувгаар ашиглахаар бүртгүүлсэн банкин дахь төгрөгийн харилцах, хугацаагүй хадгаламж, төлбөрийн картын данс, эсхүл интернэт сувгаар ашиглахаар бүртгүүлсэн төгрөгийн болон гадаад валютын харилцах, хадгаламж, зээл, төлбөрийн картын дансыг;
 - 1.2.6. “Хэрэглэгчийн нэр” гэж интернэт сувгаар үйлчилгээ авах бүрт хэрэглэгдэх, харилцагчийн сонгосон латин үсэг, араб тоо, тэмдэгт бүхий интернэт сувгийн системд өөр хэрэглэгчийн нэртэй давхцахгүй 4-16 хүртэлх тэмдэгтийг;
 - 1.2.7. “Нууц код” гэж мобайл сувгийн хувьд харилцагч үйлчилгээг ашиглан дансны мэдээлэл авах, бэлэн бус гүйлгээ хийх бүрт хэрэглэгдэх дөрвөн оронтой тоог, интернэт сувгийн хувьд үйлчилгээнд нэвтрэх бүрт хэрэглэгдэх харилцагчийн оруулсан том жижиг латин үсэг, араб тоо, тэмдэгтээс бүрдсэн 6-16 хүртэлх тэмдэгтийг;
 - 1.2.8. “Гүйлгээ баталгаажуулах код” гэж мобайл сувгийн хувьд гүйлгээ хийх бүрт гүйлгээг баталгаажуулахын тулд үйлчилгээний системээс явуулж буй санамсаргүйгээр сонгогдсон гурван үсгийг, интернэт сувгийн хувьд харилцагчийн гүйлгээ хийх бүрт хэрэглэгдэх 6 буюу түүнээс дээш оронтой тоо, тэмдэгт бүхий нууц код, эсхүл өөрийн эзэмшлийн васко төхөөрөмжөөс мэдээллэж буй кодыг тус тус хэлнэ;
 - 1.2.9. “Васко төхөөрөмж” гэж интернэт сувгаар төлбөр тооцоо хийх бүрт гүйлгээг баталгаажуулах зорилго бүхий нэг удаагийн гүйлгээний нууц код өгөх нууцлалын төхөөрөмжийг;
 - 1.2.10. “Васко код” гэж гүйлгээ хийх бүрт солигдож байдаг, васко төхөөрөмжөөс өгч буй 6 оронтой нэг удаагийн гүйлгээний нууц кодыг;
 - 1.2.11. “Бүртгэлтэй цахим шуудангийн хаяг” гэж харилцагчийн интернэт сувгаар үйлчилгээ авахтай холбоотой бүхий л нууцлал болон мэдээллийг илгээх цахим шуудангийн хаягийг;
 - 1.2.12. “Агент” гэж харилцагчид мобайл сувгаар үйлчилгээ үзүүлэх зорилгоор Банктай хамтран ажиллахаар гэрээ байгуулан үйлчилгээ үзүүлж буй иргэн, аж ахуйн нэгжийг;

ХОЁР. ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ, ТҮҮНИЙ НӨХЦӨЛ

- 2.1. Цахим үйлчилгээг мэдээллийн технологийн шийдэл, холбогдох хэрэгслүүдийг ашиглан авч байгаатай холбогдуулан харилцагч доорх нөхцлийг хүлээн зөвшөөрсөн болно.
 - 2.1.1. Харилцагчийн банкны тусгай дугаарт илгээсэн гар утасны мессеж, цахим шуудан түүний хаяг, интернэт сувгийн цахим хуудсанд оруулсан өгөгдөл, нууц код, гүйлгээ баталгаажуулах код, васко код нь харилцагч өөрөө банкинд хандан гаргасан холбогдох хүсэлт,

- төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэр, төлбөр тооцооны баримтад зурсан гарын үсэг, санхүүгийн болон бусад тамга, тэмдэгтэй нэгэн адил тооцогдоно.
- 2.1.2. Банк энэхүү гэрээний 2.1.1-т заасан болон бусад хэсэгт заасан бүрдүүлбэрийг үндэслэн гүйлгээг шууд гүйцэтгэнэ.
- 2.1.3. Цахим үйлчилгээг авах арга хэрэгсэл, үйлчилгээг авахтай холбоотой банкнаас өгсөн заавар, нууц код, баталгаажуулах код, гүйлгээний код, хэрэглэгчийн нэр, нууц үг, васко төхөөрөмж болон цахим шуудан, гар утсаар хүлээн авсан мэдээлэл зэргийг бусдад алдсан, ашиглуулсан, эсхүл тийнхүү ашиглуулах боломж олгосноос үүссэн үр дагаварыг харилцагч бүрэн хариуцна.
- 2.1.4. Харилцагчийн бүртгэлтэй цахим шуудангийн хаяг, гар утсанд очсон мэдээлэл, нууц код нь цахим үйлчилгээний нууцлалын салшгүй нэг хэсэг бөгөөд хэрэглэгч цахим үйлчилгээний нууцлалыг чандлан хадгална.
- 2.1.5. Техникийн үзүүлэлтийн хувьд васко төхөөрөмжийн баталгаат хугацаа нь энэхүү гэрээг байгуулсанаас хойш 2 жилийн хугацаатай байх бөгөөд уг хугацаанаас хойш васко төхөөрөмжийн зай дууссан, ажиллагаа нь доголдсон тохиолдолд харилцагч дахин шинэ төхөөрөмж худалдан авна.
- 2.2. Банк нь дараах Цахим сувгийн үйлчилгээг харилцагчид үзүүлнэ:
- 2.2.1. Мобайл сувгаар:
- 2.2.1.1. Харилцагч өөрийн үндсэн дансны болон бусад дансны үлдэгдэл шалгах;
- 2.2.1.2. Сүүлийн 3 гүйлгээний мэдээлэл шалгах;
- 2.2.1.3. Банк дахь өөрийн болон бусад этгээдийн дансанд шилжүүлэг хийх;
- 2.2.1.4. Төлбөр хүлээн авагч байгууллагад бараа, ажил үйлчилгээний тогтмол болон нэг удаагийн төлбөр төлөх;
- 2.2.1.5. Банктай хамтран ажилладаг агентын сүлжээгээр дамжуулан данснаасаа бэлэн зарлага гаргах, дансанд бэлэн орлого хийх;
- 2.2.2. Интернэт сувгаар:
- 2.2.2.1. Дансны хуулга, үлдэгдэл шалгах;
- 2.2.2.2. Зээлийн эргэн төлөлтийн хуваарь шалгах;
- 2.2.2.3. Банк дахь данс хооронд болон банк хооронд бэлэн бус төлбөр тооцоо гүйцэтгэх;
- 2.2.2.4. Нууц кодоо солих;
- 2.2.2.5. Банкны бэлэн ба бэлэн бус валютын арилжаанд мөрдөгдөж буй ханшийн мэдээ авах;
- 2.2.3. Хас-Info үйлчилгээгээр:
- 2.2.3.1. Харилцагчийн тус үйлчилгээнд бүртгүүлэхээр тодорхойлсон дансанд хийгдсэн гүйлгээ, үлдэгдлийн талаар мэдээллийг харилцагчийн гар утасны дугаар, цахим шуудангийн хаягаар автоматаар мэдээлэх;
- 2.3 Цахим үйлчилгээний гарын авлагыг банк энэхүү гэрээг байгуулахад харилцагчид хүлээлгэн өгсөн болно. Банк 2.2-т заасан үйлчилгээний төрлийг өөрчлөх, нэмэгдүүлэх эрхтэй бөгөөд үйлчилгээнд орсон аливаа өөрчлөлттэй холбоотой заавар, мэдээллийг банк өөрийн салбар, тооцооны төв болон агентаар дамжуулан эсхүл мессеж, цахим хуудсанд байршуулах хэлбэрээр харилцагчид мэдэгдэх ба үүнийг мөн үйлчилгээтэй холбоотой заавар гэж ойлгоно.
- 2.4 Банк цахим үйлчилгээг үзүүлэхдээ монгол хэлээр кирилл, латин үсгээр мэдээллийг дамжуулна. Харилцагч өөрийн хүсэлтээр цахим үйлчилгээг англи хэл дээр авах боломжтой бөгөөд энэ тохиолдолд цахим үйлчилгээтэй холбоотой харилцагчид очих бүх мэдээлэл англи хэл дээр байна.
- 2.5 Банк харилцагчийн цахим үйлчилгээний данс дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд багтаан төлбөр тооцоог гүйцэтгэнэ. Харилцагчийн дансны үлдэгдэл нь тухайн гүйлгээг хийхэд хүрэлцэхгүй, бүрдүүлбэр дутуу, өгөгдөл буруу зэргээс шалтгаалан гүйлгээ саатсаны улмаас учирсан үр дагавар, хохирлыг банк хариуцахгүй.
- 2.6 Үйлчилгээний жилийн хураамж, гүйлгээний шимтгэл хураамжийн хэмжээ, нэг өдөрт хийх гүйлгээний тоо болон дүнгийн хязгаар зэргийг Банкны “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл” /цаашид “үйлчилгээний ерөнхий нөхцөл” гэх/-өөр тогтоох бөгөөд банк үйлчилгээний ерөнхий нөхцөлийг харилцагчид урьдчилан мэдэгдэх үүрэг хүлээхгүй.
- 2.7 Мобайл сувгаар үйлчилгээг авахаар харилцагчийн илгээсэн мессежний төлбөр нь түүнийг мессеж илгээсэн тухай бүрт тооцогдож харилцагчийн гар утасны нэгжээс хасагдана.
- 2.8 Банк нь харилцагчийн цахим үйлчилгээгээр хийх төлбөр тооцоог 24 цагийн турш хийж гүйцэтгэнэ.
- 2.9 Интернэт сувгаар хийгдэж буй банк хоорондын гүйлгээ нь Монголбанкны гүйлгээ хүлээн авах цагийн хуваарийн дагуу дамжуулагдана.
- 2.11. Харилцагч үйлчилгээний ерөнхий нөхцөлд зааснаас өөр дүнгээр гүйлгээний хязгаарыг тогтоолгож болох бөгөөд интернэт сувгийн хувьд энэ нь зөвхөн тухайн валютаараа хийгдэх гүйлгээнд хамаарна.

- 2.12. Энэхүү гэрээнд тусгаагүй цахим үйлчилгээний нөхцөл, журмыг тухайн үйлчилгээг үзүүлэх явцад хэрэглэгдэж буй маягт, цахим үйлчилгээ авах хүсэлт, тухайн үйлчилгээг үзүүлэх бусад шатанд банкнаас илгээж байгаа мэдээлэл, гарын авлага зэргээр тогтоосон гэж үзнэ.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Энэхүү гэрээгээр банк дараах эрхийг эдэлнэ:
- 3.1.1. Үйлчилгээний ерөнхий нөхцөлд заасны дагуу харилцагчаас үйлчилгээний хураамж, шимтгэлийг бэлэн болон бэлэн бусаар авах эсвэл мобайл болон интернэт сувгаар хийгдсэн гүйлгээний шимтгэлийг тухайн зарлагын гүйлгээ хийгдэх данснаас суутгах ба дансны үлдэгдэл шимтгэл, хураамжийг суутгахад хүрэлцэхгүй бол гүйлгээ хийгдэхгүй;
 - 3.1.2. ХасInfo үйлчилгээний шимтгэлийг харилцагчид мэдээлэл хүргэх тухай бүр харилцагчийн шимтгэл тооцох данснаас суутгах ба хэрэв харилцагчийн дансан дахь үлдэгдэл хүрэлцэхгүй бол Банк ХасInfo үйлчилгээг үзүүлэхгүй;
 - 3.1.3. Харилцагч цахим сувгаар банкнаас тогтоосон валютын арилжааны гүйлгээний дүнгээс илүү дүнтэй арилжааны гүйлгээ хийхдээ банктэй зөвшилцөлгүйгээр гүйлгээ хийсэн тохиолдолд банк ханшийн зөрүүг харилцагчийн данснаас суутган авах, шаардлагатай бол уг гүйлгээг буцаах;
 - 3.1.4. Харилцагч цахим үйлчилгээний эрхээ өөрийн хүсэлтээр хаалгах тохиолдолд Банк харилцагчийн төлсөн жилийн хураамж, болон Васко төхөөрөмжийн үнийг буцаан олгохгүй.
- 3.2. Энэхүү гэрээгээр банк дараах үүрэг хүлээнэ:
- 3.2.1. Харилцагчид Цахим үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай үзүүлэх;
 - 3.2.2. Интернэт сувгийг ашиглах харилцагчийн банкнаас худалдан авсан Васко төхөөрөмж нь хэрэглэгчийн буруутай үйлдлээс бусад тохиолдлоор эвдрэл гэмтэлтэй, баталгаат хугацаа дуусахаас өмнө зай нь дууссан нь нь тогтоогдсон тохиолдолд үнэ төлбөргүйгээр хэвийн ажиллагаатай төхөөрөмжөөр сольж өгөх;
 - 3.2.3. Гадаад төлбөр тооцоо гүйцэтгэж буй харилцагч нь дамжуулагч бусад банкны шимтгэлийг төлөх нөхцөлийг сонгосон тохиолдолд уг шимтгэлийн дүнг харилцагчийн Банкин дахь харилцах, хугацаагүй хадгаламж, картын данснаас суутган авах;
 - 3.2.4. Харилцагчийг цахим үйлчилгээний гарын авлагаар хангах;
 - 3.2.5. Харилцагчийн мобайл сувгаар үйлчилгээ авах хүсэлт нь банк, түүний ажилтны буруутай үйл ажиллагааны улмаас биелэгдээгүй бөгөөд гар утасны нэгжийн зардал харилцагчаас гарсан бол харилцагчийн гомдлыг түргэн шуурхай барагдуулах;
 - 3.2.6. Банк нь харилцагчийн дансны нууцыг хадгалж, гүйлгээний болон бусад хувийн мэдээллийг Монгол Улсын хууль, тогтоомжид зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй байх;
 - 3.2.7. Банкны буруутай үйл ажиллагааны улмаас харилцагч, мобайл суваг дээр хамтран ажиллагч агентын хооронд үүссэн маргаантай асуудлыг гурван талын оролцоотойгоор шийдвэрлэх;
 - 3.2.8. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.
- 3.3. Харилцагч энэхүү гэрээгээр дараах эрх эдэлнэ:
- 3.3.1. Энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг банкнаас шаардах;
 - 3.3.2. Өөрийн дансны үлдэгдэл, цахим үйлчилгээгээр хийсэн төлбөр тооцоо, үйлчилгээтэй холбоотой асуудлаар банкнаас тайлбар авах;
 - 3.3.3. Салбар, тооцооны төвд өөрийн биеэр хүрэлцэн ирж цахим үйлчилгээгээр хийсэн бэлэн бус гүйлгээний баримт болон дансны сүүлийн нэг сарын хуулгыг нэг удаа үнэ төлбөргүй хэвлүүлэн авах;
 - 3.3.4. Харилцагч агентаар дамжуулан мобайл сувгаар бэлэн гүйлгээ хийсэн тохиолдолд агентад бэлэн мөнгө хүлээлгэн өгсөн эсхүл агентаас бэлэн мөнгө хүлээн авсан баримтыг гүйлгээ хийсэн тухайн агшинд агентаас авах;
 - 3.3.5. Үйлчилгээний эрх сунгах, бүртгүүлсэн дансны болон үйлчилгээний мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, хаах хүсэлтийг банкинд бичгээр гаргаж шийдвэрлүүлэх;
 - 3.3.6. Харилцагч интернэт банкны үйлчилгээнд бүртгүүлсэн бол васко төхөөрөмжийг банкнаас худалдан авах;
 - 3.3.7. Хууль тогтоомжид заасан бусад эрх.
- 3.4. Харилцагч энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ:
- 3.4.1. Банкны үйлчилгээний ерөнхий нөхцөлд заасан мөнгөн хөрөнгийг өөрийн дансанд байршуулж, үйлчилгээний үнэ, хураамж, шимтгэлийг үл маргах журмаар төлөх;
 - 3.4.2. Үйлчилгээг гарын авлагад заасны дагуу хүсэлт илгээж авах бөгөөд гарын авлагад зааснаас өөрөөр хүсэлт ирүүлсний улмаас үүссэн хохирлыг бүрэн хариуцах;

- 3.4.3. Энэхүү гэрээний 1.2-т заасан нууцлалын тэмдэгтүүд болон төхөөрөмжийг бусдад дамжуулахгүй байх бөгөөд дамжуулснаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;
- 3.4.4. Үйлчилгээнд бүртгүүлсэн мэдээлэл нь өөрчлөгдсөн болон нууцлалын тэмдэгтүүдийг алдсан тохиолдолд банкинд нэн даруй мэдэгдэх ба банкинд мэдэгдээгүйгээс буюу мэдэгдэхээс өмнө үүссэн аливаа асуудлыг хариуцах;
- 3.4.5. Мобайл сувгаар дансандаа бэлнээр орлого, зарлагын гүйлгээ хийх тохиолдолд иргэний бичиг баримттайгаа агент дээр ирнэ;
- 3.4.6. Мобайл сувгийг ашиглахдаа нууцлалыг хангах үүднээс гар утаснаасаа илгээсэн хүсэлт болон Банкнаас хүлээн авсан мессежийг гүйлгээ хийгдсэн тухай бүрт устгах. Ийнхүү устгаагүйгээс нууц код болон дансны мэдээллээ бусдад алдсанаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;
- 3.4.7. Интернет сувгаар банкнаас тогтоосон валютын арилжааны гүйлгээний дүнгээс илүү дүнгээр валютын арилжааны гүйлгээ хийх тохиолдолд банкинд урьдчилан мэдэгдэж арилжааны гүйлгээ хийх зөвшөөрөл авах;
- 3.4.8. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 4.1. Энэхүү гэрээ нь харилцагчийн цахим үйлчилгээний эрхээ хаалгах хүсэлт гаргах хүртэл хугацаанд хүчинтэй байх ба харилцагч цахим үйлчилгээний эрхээ хаалгах хүсэлт гаргаснаар гэрээний хугацаа дуусгавар болно.
- 4.2. Харилцагч энэхүү гэрээгээр тохиролцсон үүргээ биелүүлээгүй, үйлчилгээний ерөнхий нөхцөлд заасан хураамж шимтгэлийг төлөөгүй, үүссэн бусад тооцоог барагдуулаагүй тохиолдолд банк нэг сарын хугацаанд үйлчилгээ авах эрхийг түр хаах бөгөөд энэ хугацааны дотор харилцагч хураамж, тооцоог барагдуулаагүй тохиолдолд банк энэ гэрээг нэг талын санаачилгаар цуцалж үйлчилгээний эрхийг бүр хаана.
- 4.3. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 4.4. Цахим үйлчилгээний гарын авлага болон гэрээний хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 5.1. Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.
- 5.2. Гэрээтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.
- 5.3. Энэхүү гэрээний 5.2-т заасан журмаар маргааныг шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.